

Хууль зүйн сайдын 2016 оны
А/204 дүгээр тушаалаар батлав.



МОНГОЛ УЛС
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

000159628

2018.02.07

/ Бүртгэсэн он, сар, өдөр /

9071086095

/ Хувийн хэргийн дугаар /

1022504

/ Регистрийн дугаар /

Монголын усан спорт сонирхогчдын холбоо

Нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага

/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /

Дүрэм

/ Үүсгэн байгуулах баримт бичиг /

Тогтоол

01

1999.03.24

/ шийдвэрийн нэр /

/ дугаар /

/ он, сар, өдөр /

Усан спорт сонирхогч иргэдийн авъяас, ур чадварыг нээн хөгжүүлэх, тамирчид бэлтгэх,
сургалт, уралдаан, тэмцээн зохион байгуулах, ижил зорилготой байгууллагуудтай
хамтран ажиллах

9499

/ код /

/ Үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл /

/ код /

/ Туслах эрхлэх үйл ажиллагааны чиглэл /

Хугацаагүй

1

0.0

/ хугацаа /

/ гишүүдийн тоо /

/ өөрийн хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр /

Улаанбаатар, Хан-Уул, 1-р хороо, чингисийн өргөн чөлөө, Капитал хаус 1 давхар, Утас1: 94112008, Утас2:
85050289, Факс:

/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг /



Оюуны өмч, улсын бүртгэлийн
ерөнхий газар Хуулийн этгээдийн
бүртгэлийн газар
/ бүртгэсэн байгууллагын нэр /

Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

Д/д	Нэмэлт өөрчлөлтийн агуулга	Бүртгэсэн	
		Огноо	Ажилтан тэмдэг
1	Пүрэв овогтой Батсайхан-а УЗД, ерөнхийлөгч-р томилсныг бүртгэв.	2018.02.07	Д.Лэхсэ


Энэхүү гэрчилгээг хуурамчаар үйлдсэн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу харуунцага хүлээгэнэ.
Улсын бүртгэлийн гэрчилгээг засвартай бол хүчингүй.



★ 0 0 0 1 5 9 6 2 8 ★



МУССХ-ны Их Хурлаар 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдөр шинэчлэн найруулав.



МОНГОЛЫН УСАН СПОРТ СОНИРХОГЧДЫН ХОЛБООНЫ ДҮРЭМ (Шинэчилсэн найруулга)

Нэг. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Байгууллагын нэр: “Монголын Усан Спорт Сонирхогчдын Холбоо”, товчлол нь МУССХ (цаашид “Холбоо” гэх), англи хэлээр: Mongolian Amateur Swimming Federation, товчлол нь MASF.
- 1.2 Байгуулагдсан он, сар, өдөр: 1991 оны 01-р сарын 01-ний өдөр.
- 1.3 Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүргийн 1 дүгээр хороо, Чингисийн өргөн чөлөө-48/1, “Капитал хауз”-ын 1 дүгээр давхар
- 1.4 Холбоо нь усан спортыг сонирхогч, хичээллэгч, дэмжигчдийн сайн дурын үндсэн дээр байгуулагдсан, гишүүнчлэлтэй, Монгол Улсад усан спортыг хөгжүүлэх үндсэн зорилготой, нийгэмд үйлчилдэг, ашгийн төлөө бус төрийн бус байгууллага мөн.
- 1.5 Холбоо нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Төрийн бус байгууллагын тухай хууль болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулна.

Хоёр. МУССХ-НЫ ЭРХЭМ ЗОРИЛГО, ЗОРИЛТ

- 2.1 Монгол Улсад усан спортыг эрчимтэй хөгжүүлэх, энэ спортод Монгол хүний оролцоог нэмэгдүүлэх, олон улс, тив, дэлхий, Олимпийн наадамд өрсөлдөх амжилт гаргах боломжийг нэмэгдүүлэх, өндөр зэрэглэлийн тамирчдыг бэлтгэх, усан спортоор эх орноо олон улсад сурталчлах нь Холбооны эрхэм зорилго болно.
- 2.2 Усан спортыг сонирхогч, хичээллэгч, дэмжигчдийн үйл ажиллагааг нэгтгэн зохион байгуулж, удирдан чиглүүлнэ.
- 2.3 Эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг явуулах санал, санаачлагыг хөхиүлэн дэмжиж, олон улсын туршлагаас суралцаж, Монгол хүний онцлогт тохирсон сургалт, дасгалжуулалтын шинэ аргачлалыг бий болгон хэрэгжүүлнэ.

- 2.4 Дасгалжуулагч, тамирчин бэлтгэх сургалт дасгалжуулалтыг явуулах орчин, нөхцөлийг бүрдүүлнэ.
- 2.5 Өөрийн оронд бүх шатны тэмцээн зохион байгуулж өндөр зэрэглэлийн, дэлхийн түвшинд амжилт гаргахуйц тамирчдыг бэлтгэж олон улс, тив, дэлхий, Олимпын наадамд оролцуулна.
- 2.6 Усан спортыг дэлгэрүүлэх хөгжүүлэх зорилтын хүрээнд сонирхогч, хичээллэгчдийн дунд сургалт, хүмүүжлийн ажлыг тогтмол зохион явуулж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилна.
- 2.7 ОУУСХ, АУССХ болон бусад олон улс, гадаадын байгууллагуудтай усан спортыг хөгжүүлэх, материаллаг баазыг бэхжүүлэх чиглэлээр хамтын ажиллагаагаа хөгжүүлэхэд гадаад бодлого чиглэгдэнэ.
- 2.8 Холбооны бие даасан байдлыг бэхжүүлэх зорилгоор төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэд, гадаадын хандивлагч байгууллага, хувь хүмүүстэй гэрээний үндсэн дээр хамтран ажиллана.

Гурав. ХОЛБООНЫ ҮҮРЭГ

- 3.1 Өөрийн орны онцлогт тохирсон усан спортыг хөгжүүлэх бодлого боловсруулах, улмаар төр, олон нийтийн байгууллага, дэмжигчдийн дэмжлэг авч хэрэгжүүлэх.
- 3.2 Олимпын хөдөлгөөний үзэл санааг дэмжиж, олон улс болон тивийн усан спортын холбооны дүрэм, зааврыг биелүүлэх.
- 3.3 Усан спортын тамирчдыг системтэй бэлтгэх, залгамж халаа тамирчдыг бэлдэх спортын ур чадварыг нь байнга дээшлүүлэх нөхцөл боломжийг бүрдүүлэх.
- 3.4 Бүх нас, зэрэглэлийн тамирчдын ур чадварт тохирсон улсын чанартай болон клуб хоорондын тэмцээнүүдийг жилийн график төлөвлөгөө гарган тогтмол, системтэйгээр зохион байгуулах.
- 3.5 Усан спортын мэргэжлийн хүний нөөцийг бэлтгэх, давтан сургах, сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгох нөхцөл, боломжийг нэмэгдүүлэх.
- 3.6 Усан спортын материаллаг баазыг бэхжүүлэх чанаржуулах, санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах.
- 3.7 Олон Улс болон Тив, Үндэсний Холбоодтой харилцаа холбоо тогтоож, үр ашигтай хамтын ажиллагаа өрнүүлэх.
- 3.8 Монгол Улсын нутаг дэвсгэрт бүх зэрэглэлийн тэмцээнүүдийг удирдан зохион байгуулах, хянах, мэргэжлийн туслалцаа үзүүлэх, үйл ажиллагааг уялдуулах.
- 3.9 Усан спортыг дэмжигч байгууллага, хамт олны үүсгэл, санаачлагыг дэмжиж хамтран ажиллах, хоорондын уялдаа холбоог нь хангах.

- 3.10 Усан спортын мэргэжлийн хүний нөөцийг бэлтгэх, мэргэжил дээшлүүлэхэд чиглэгдсэн гишүүн клубүүдийн сургалтын хөтөлбөрийг дэмжих.
- 3.11 Усан спортын шинэ ба шинэчлэгдсэн дүрэм, журам, заавар, норм, норматив, стандартыг боловсруулах, боловсруулсан материалд шүүлт хийх.
- 3.12 Усан спортын хэтийн чиг хандлага, холбогдолтой судалгаа, мэдээллийг олон улсын хэмжээнд солилцоход идэвхтэй оролцож, мэдээллийн санг ажиллуулах.

Дөрөв. ХОЛБООНЫ ЭРХ

- 4.1 Усан спортыг хөгжүүлэх талаар төр засаг болон холбогдох олон нийтийн байгууллагад санал, хүсэлт гаргах шийдвэрлүүлэх.
- 4.2 Олимп, дэлхий, тивийн болон бусад олон улсын чанартай тэмцээнд оролцох баг МУССХ нь усан спортыг сурталчлах, хичээллэгсэдийн тоог нэмэгдүүлэх, усан спортын материаллаг бааз, хүний нөөцийг нэмэгдүүлэх, бэлтгэл сургалтыг сайжруулах, өндөр ур чадвартай дасгалжуулагчид, тамирчид бэлтгэж зохион байгуулах.
- 4.3 Олимпийн хөдөлгөөнийг дэмжиж, олон улс, тивийн болон гадаад бусад орнуудын усан спортын холбоодтой хамтын идэвхтэй үйл ажиллагаа явуулж тэдний дэмжлэг туслалцааг авна.
- 4.4 Холбоо нь Монголын Үндэсний Олимпийн Хорооны бүрэлдэхүүн хэсэг бөгөөд олон улс, тивийн усан спортын холбоодын өмнө өөрийн улсын тухайн чиглэлээр төлөөлөх эрхийг эдэлж, эх орноо олон улсад сурталчлах бөгөөд олон улс, тивийн усан спортын холбоодын гишүүн байна.
- 4.5 Холбооны үйл ажиллагаа нь ил тод, бие даасан байх бөгөөд үүнд Монгол Улсын хууль тогтоомж, энэ дүрмийг удирдлага болгоно.
- 4.6 Холбоо нь хуулийн этгээд бөгөөд өөрийн бэлгэ тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас, гишүүдийн үнэмлэх, энгэрийн тэмдэг болон төрийн бус байгууллагын тэмдэгтэй байна.
- 4.7 Холбооны эрхэм зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд онцгой үүрэг гүйцэтгэсэн холбооны гишүүн, гадаад дотоодын иргэн, хуулийн этгээдийг холбооны хүндэт гишүүнээр өргөмжилж болно. Хүндэт гишүүнээр сонгох болзол журмыг Удирдах Зөвлөл тогтооно.
- 4.8 Тамирчдын бүрэлдэхүүнийг (шударгаар, ил тод сонгон шалгаруулж) батлах.
- 4.9 Тамирчин, шүүгч, дасгалжуулагчдад спортын цол зэрэг олгох, хасах, бууруулах.
- 4.10 Олон улс болон тивийн холбооны шугамаар зохиогдох хурал, зөвлөлгөөн, семинар, курс зэрэг арга хэмжээнд өөрийн төлөөлөгчдийг оролцуулах.

- 4.11 Олон улс, тив, бусад үндэсний холбоод, өөрийн болон гадаад орны бүх хэлбэрийн байгууллагуудтай харилцан ашигтай хамтран ажиллах асуудлаар гэрээ хэлцэл байгуулах.
- 4.12 Усан спортын сургалтын ажлыг шалган зөвлөх, түүнийг хариуцдаг багш, дасгалжуулагч нарын илтгэл саналыг гүйцэтгэх хорооны хурлаар хэлэлцэж, зохих шийдвэр гаргах.
- 4.13 Усан спортын тэмцээний албан ёсны дүрэм, түүнд орсон нэмэлт өөрчлөлтийг улсын хэмжээнд сурталчлах, мөрдүүлэх.
- 4.14 Холбооны бэлгэдэл, усан спорттой холбогдсон аливаа зүйлийн эрхийг худалдах, патентын гэрээний үндсэн дээр ашиглуулах.
- 4.15 Усан спортыг хөгжүүлэх үйлсэд тодорхой хувь нэмэр оруулсан, гарамгай амжилт гаргасан хүнийг Монгол улсын алдар цол, төрийн дээд болон Засгийн газар, Монголын Үндэсний Олимпийн Хорооны шагналаар шагнуулах саналыг зохих журмын дагуу эрх бүхий байгууллагад оруулах.
- 4.16 Олон улсын болон улс, орон нутгийн тэмцээнийг зохион байгуулах эрхийг бусдад олгох, худалдах.

Тав. ХОЛБООНЫ ГИШҮҮНЧЛЭЛ

- 5.1 Монголын Усан Спорт Сонирхогчдын Холбоо нь өөрийн гишүүдтэй байна. Энэ дүрмийг хүлээн зөвшөөрсөн усан спортын клубүүд, хувь хүн, хуулийн этгээд Холбооны гишүүн байж болно.
- 5.2 **Гишүүн клуб** нь 2 түвшний зэрэглэлтэй байна. Клубыг гишүүнээр бүртгэх, зэрэглэх журмыг Удирдах Зөвлөлөөс батална.
- 5.3 **Хувь хүн** (үүнд, Тамирчид, Шүүгч, Дасгалжуулагч болон 18 насанд хүрсэн эрхзүйн чадамжтай бусад хүн байна.)
- 5.4 **Хуулийн этгээд**
- 5.5 Гишүүн клубын эрх барих байгууллага нь клубын бүх гишүүдийн хурал мөн. Эдгээр клуб нь өөрийн Зөвлөлтэй байж болно.
- 5.6 Клуб нь хүүхэд, залуучуудыг болон тамирчдыг хичээллүүлэх өөрийн буюу түрээсийн усан бассейн, спортын бусад материаллаг бааз, суурьтай байна.
- 5.7 Усан спортын шигшээ багийг аймаг, нийслэлийн болон Холбооны шугамаар зохион байгуулна. Тэгэхдээ шигшээ багийн тамирчид нь аль нэг клубт тогтмол хичээллэх бөгөөд олон улсын буюу бусад тэмцээнд оролцох зорилгоор нэгдсэн бэлтгэл сургуулилтаа хангадаг байх журмыг мөрдөнө.

Зургаа. ГИШҮҮНИЙ ҮҮРЭГ

- 6.1 Холбооны гишүүн нь тус холбооны үйл ажиллагааны үндсэн чиглэл, дүрмийг удирдлага болгон ажиллана.
- 6.2 Холбооны дүрэм, Удирдах зөвлөлөөс баталсан журмуудыг чанд сахиж, холбооны үйл ажиллагаанд идэвхи санаачлагатай оролцож, гишүүний татварыг энэ дүрэмд заасан хугацаанд бүрэн төлнө. Татварыг тогтоосон хугацаанд тогтоосон хэмжээгээр төлөөгүй тохиолдолд ээлжит болон ээлжит бус их хуралд оролцох эрхгүй.
- 6.3 Холбооны гишүүн нь Монгол Улсын усан спортын хөгжилд бодитой хувь нэмэр оруулах, аливаа санал, санаачлага гаргах, өөрийн болон гадаад орнуудад усан спортыг хөгжүүлж буй туршлагыг судалж бүтээлчээр хэрэгжүүлнэ.
- 6.4 Ёс зүйн болон санхүүгийн зөрчил болон Холбооны дүрэмд харш үйлдэл гаргахгүй байх үүрэгтэй. Тамирчин гишүүн дотоод гадаадын уралдаан тэмцээнд оролцох болбол зохих бэлтгэл сургуулилтыг хийж, хамт олон, улсыг төлөөлөх нөхцөл боломжоо дээд хэмжээнд дайчлах.
- 6.5 Дэлхийн Допингийн эсрэг дүрэм, Монгол Улсын Допингийн эсрэг дүрмийг мөрдөн ажиллах.
- 6.6 Тамирчин гишүүн нь Удирдах Зөвлөлийн гаргасан шийдвэрийг биелүүлэх ба клуб хооронд шилжихдээ Холбооны Удирдах Зөвлөлийн баталсан тамирчид шилжих журмыг баримтална.

Долоо. ГИШҮҮНИЙ ЭРХ

- 7.1 Холбооны гишүүн нь Холбооны бүх шатны байгууллагад сонгох, сонгогдох.
- 7.2 Холбоо болон усан спортын тухай аливаа асуудлыг хэлэлцэн шийдвэрлэхэд ажил хэрэгчээр идэвхтэй оролцох.
- 7.3 Дотоод, гадаадын тэмцээн уралдаан бусад арга хэмжээнд өөрийн байгууллага, хамт олон, эх орноо төлөөлж, зохих бэлтгэлтэйгээр оролцох.
- 7.4 Спортын бассейн буюу танхим, хувцас форм, хэрэглэл, материал, тоног төхөөрөмжийг тогтоосон журмын дагуу ашиглах.
- 7.5 Өөрийн орны болон дэлхийн усан спортын үйл явдал, технологийн дэвшилд суурилсан өөрчлөлтийн талаарх мэдээлэлийг холбоогоор дамжуулан түгээх.
- 7.6 Үр бүтээлтэй ажиллаж, спортын өндөр амжилт гаргасны төлөө материалын болон сэтгэл санаа, нэр хүндийн урамшил хүртэх.
- 7.7 Холбооны гишүүн байгууллага нь Холбооноос зохион явуулж байгаа уралдаан тэмцээнд оролцохдоо эрхийн хураамж төлөхгүй байх.

Найм. ГИШҮҮНЭЭР ЭЛСЭХ, ГИШҮҮНЧЛЭЛИЙН ЭРХ ДУУСГАВАР БОЛОХ ТУХАЙ

- 8.1 Холбоонд гишүүнээр элсэхийг хүссэн хувь хүн, байгууллага, клуб Холбооны удирдах зөвлөлд энэ тухай хүсэлт гаргаж шийдвэрлүүлнэ.
- 8.2 Гишүүнчлэлийн үндсэн шаардлага, гишүүн элсүүлэхтэй холбоотой зохицуулалтыг Удирдах зөвлөлийн хурлаар баталсан “Гишүүнчлэлийн журам”-аар зохицуулна.
- 8.3 Холбоонд гишүүнээр элссэн хувь хүн нь гишүүнчлэлийн үнэмлэх, энгэрийн тэмдэгтэй, байгууллага болон клуб нь гэрчилгээтэй байна.
- 8.4 Дараах үндэслэлээр гишүүнийг гишүүнчлэлээс хөөнө. Үүнд:
 - 8.4.1 Холбооны эрхэм зорилго, тунхаг, зарчим, Үндсэн дүрэм, байгууллагын дүрэм, журмыг удаа дараа болон ноцтой зөрчсөн, байгууллагын нэр хүндийг унагаасан, хохирол учруулсан, Ёс зүйн дүрэм ноцтой зөрчсөн
 - 8.4.2 Усан спортын нэр хүндэд харш үйлдэл хийсэн.
- 8.5 Клуб, хуулийн этгээдийн гишүүнчлэлээс хасах шийдвэрийг Удирдах зөвлөл энэ дүрмийн 8.1-д заасан үндэслэлээр гаргана.
- 8.6 Гишүүн нь гишүүнчлэлээсээ хөөгдсөн тохиолдолд тус байгууллагын бүхий л үйл ажиллагаанд оролцох эрх нь хаагдах бөгөөд ийнхүү хөөгдсөн нь буруутай үйлдлийн улмаас бусдад учруулсан бодит хохирлыг барагдуулах хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.
- 8.7 Гишүүнчлэлээс хасагдсан, хөөгдсөн тохиолдолд тухайн жилийн гишүүний татвар, бусад мөнгөн хандивыг эргүүлэн олгохгүй.
- 8.8 Холбоо нь бүх гишүүддээ эрх тэгш үйлчлэх бөгөөд аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхахыг хориглоно.
- 8.9 Гишүүнээс хасах, хөөх талаарх нарийвчилсан зохицуулалтыг энэхүү дүрмээр тогтоосон зарчмын хүрээнд “Гишүүнчлэлийн журамд” зааж болно.

Ес. МУССХ-НЫ УДИРДЛАГЫН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

- 9.1. МУССХ-ны удирдлагын тогтолцоо нь дараах бүтэцтэй байна. Үүнд:
 - 9.1.1. Холбооны Их Хурал
 - 9.1.2. Удирдах зөвлөл (15 хүртэл сондгой тооны гишүүнтэй)
 - 9.1.3. Хяналтын зөвлөл - 3
 - 9.1.4. Ерөнхийлөгч – 1
 - 9.1.5. Хүндэт Ерөнхийлөгч
 - 9.1.6. Дэд ерөнхийлөгч-4
 - 9.1.7. Ерөнхий нарийн бичгийн дарга
 - 9.1.8. Аймаг, нийслэлийн болон бусад салбар холбоо;

- 9.2. Холбоо дэргэдээ Тамирчдын, Дасгалжуулагчдын, Шүүгчдийн, Ёс зүйн зөвлөлүүдтэй байх ба зөвлөлийн үйл ажиллагааг энэхүү дүрмийн хүрээнд Удирдах зөвлөлөөс гаргасан бие даасан журмаар зохицуулна.
- 9.3. Холбоо нь Эрдэм шинжилгээний судалгаа, Гадаад харилцаа, Мэдээлэл сурталчилгааны багтай байна.

Арав. ХОЛБООНЫ ИХ ХУРАЛ

- 10.1. Их хурал нь Монголын Усан Спорт Сонирхогчдын Холбооны эрх барих дээд байгууллага мөн.
- 10.2. Их хурлыг 4 жилд нэг удаа хуралдуулна. Хурал хуралдах товыг нэг сараас доошгүй хугацааны өмнө Холбооны Удирдах зөвлөлөөс тогтооно.
- 10.3. Шаардлагатай тохиолдолд Удирдах Зөвлөлийн шийдвэрээр эсхүл Ерөнхийлөгчийн зарласнаар ээлжит бус Их хурлыг зарлан хуралдуулж болно.
- 10.4. Их хурлаар дараах үндсэн асуудлыг хэлэлцэж тогтоол гаргана. Үүнд:
- 10.4.1. Холбооны дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах
 - 10.4.2. Холбооны Удирдах Зөвлөлийн тайлантай танилцаж, хүлээн авах;
 - 10.4.3. Холбооны Хяналтын зөвлөлийн тайлантай танилцаж, хүлээн авах;
 - 10.4.4. Холбооны Ерөнхийлөгч, Дэд Ерөнхийлөгч, Удирдах зөвлөлийн гишүүд, Хяналтын зөвлөлийн гишүүдийг сонгох.
 - 10.4.5. Бусад асуудал.
- 10.5. Их хуралд оролцох төлөөлөгчид дор дурдсан бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:
- 10.5.1. А зэрэглэлийн гишүүн клубуудын төлөөлөл - 5
 - 10.5.2. Б зэрэглэлийн гишүүн клубуудын төлөөлөл – 3
 - 10.5.3. Дасгалжуулагчийн зөвлөлийн төлөөлөл-1
 - 10.5.4. Шүүгчийн зөвлөлийн төлөөлөл-1
 - 10.5.5. Тамирчдын төлөөлөл-3
 - 10.5.6. Олон Улсын Хэмжээний Мастерууд
 - 10.5.7. Мастеруудын Холбоо – 1
 - 10.5.8. Удирдах зөвлөл – 15
 - 10.5.9. Пара тамирчдын төлөөлөл – 1

10.5.10. Холбооны хүндэт гишүүн (хувь хүн) нь Их хуралд оролцож төлөөлөгчийн саналын таслах эрхээс бусад эрхийг эдэлнэ.

10.6 Их хуралд оролцох төлөөлөгчийг дүрмийн 10.5 заасан тоонд багтаан зөвлөл, клубүүд өөрсдөө сонгоно. Төлөөлөгчид нь Холбооны албан ёсны гишүүн байх ба гишүүний үүргээ биелүүлдэг байна.

10.7 Нэгдсэн хуралдаан хэлэлцэж шийдвэрлэсэн асуудлаар “Тогтоол” гаргана.

10.8 Их хуралд оролцох төлөөлөгчдийн энгийн олонх буюу ирц 50%-с дээш бүрдсэн тохиолдолд тухайн хурлыг хүчинтэйд тооцно.

10.9 Их хуралд дараах этгээдүүд саналын эрхтэй оролцоно.

10.9.1 Дүрмийн 10.5-д заасан төлөөлөгчид;

10.10 Төлөөлөгчдийн санал тэнцсэн тохиолдолд Ерөнхийлөгч таслах эрхтэй оролцоно.

10.11 Их хуралд хэлэлцэж буй асуудлыг оролцогчдын энгийн олонхийн (50%-с дээш) саналаар шийдвэрлэнэ.

ИХ ХУРАЛ ДАХЬ СОНГУУЛЬ

10.12 МУССХ-ны Их хурлын өмнөх Удирдах зөвлөлийн хурлаар сонгуулийг зохион байгуулах чиг үүрэг бүхий хараат бус, бие даасан комиссыг байгуулна.

10.13 Хараат бус комисс нь Удирдах зөвлөлийн гишүүд, Ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч, Хяналтын зөвлөлийн гишүүдэд нэр дэвшигчдийн материалыг төрөлжүүлэн хүлээн авч бүртгэл хөтлөхөөс эхлэн сонгуулийн дүнг мэдээлэх хүртэлх Сонгуулийн бүхий л үйл ажиллагааг хараат бус, бие даасан байдлаар хариуцан ажиллана.

10.14 Хараат бус комисс нь даргыг оролцуулсан гурван хүний бүрэлдэхүүнтэй байх ба эдгээр бүрэлдэхүүн нь нэр дэвших, санал өгөх эрхгүй байна. Комиссын бүрэлдэхүүнд хууль эрх зүйн мэргэжилтэй, туршлагатай этгээдийг заавал оролцуулна. Хараат бус гишүүн нь МУССХ-ны гишүүнээр элсч байгаагүй этгээд байна.

10.15 Хараат бус, бие даасан комисс нь сонгуулийн үйл ажиллагааг зохион байгуулах түр журмыг Их хурлаас 15-с багагүй хоногийн өмнө боловсруулан гаргаж ба Холбооны ажлын алба уг журмыг нийт гишүүдэд хүргэнэ.

10.16 Их хурлын сонгуульд нэр дэвшигч нь хувь хүн байх ба дараах шаардлагыг хангасан этгээд байна.

10.16.1 Монгол Улсад усан спортыг хөгжүүлэх, МУССХолбооны гишүүд, тус спортын тамирчид, сонирхогчдын эрх ашгийг хамгаалах, Холбооны эрхэм зорилго, зорилтыг хэрэгжүүлэн ажиллах, Холбооны дүрэм, журмыг чандлан сахих чин эрмэлзэлтэй этгээд байх;

10.16.2 Урьд нь МУССХолбоо болон бусад спортын хороодод сонгуульд буюу бусад албан тушаал хаших хугацаандаа аливаа ёс зүйн болон санхүүгийн зөрчил гаргаж байгаагүй этгээд байх;

10.16.3 Ерөнхийлөгчид нэр дэвших этгээд нь сүүлийн 4 жил Холбооны гишүүнээр идэвхтэй ажиллаж, гишүүний татвараа тогтоосон хугацаанд тогтоосон хэмжээгээр төлсөн байх;

10.16.4 Бусад.

10.17 Сонгуулийг санал хураалтаар явуулна. Хэрвээ сонгуульт тухайн албан тушаалтны хяналтын тоо болон түүнд нэр дэвшигчдийн тоо тэнцүү байх тохиолдолд сонгуулийн санал хураалтыг ил явуулж болно. Бусад тохиолдолд саналын хуудас ашиглана.

10.18 Нэр дэвшигчийн бүртгэл эхлэх үед саналын хуудас хэвлэгдэх ба саналын хуудас хэвлэгдсэнээр нэр дэвшигчийн дэвших эрх нээгдсэнд тооцно.

10.19 Холбооны гишүүн холбооны удирдлагад өөрийн нэрийг дэвшүүлж бүртгүүлсэн тохиолдолд, бүртгэл хаагдсаны дараа, саналын хуудас хэвлэгдэх хүртэлх хугацаанд өөрийн хүсэлтээр нэр дэвшихээс татгалзах, өөрийн нэрийг дэвшүүлсэн албан тушаалын ангилалыг сольж өрсөлдөх эрхтэй.

10.20 Ийнхүү бүртгэл хаасны дараа, өөрийн нэрийг дэвшүүлсэн албан тушаалын ангилалыг солих тохиолдолд эрэмбийг (зөвхөн) бууруулж солих эрхтэй. *(Байршуулсан дэнчин болзолоос хамаарах тул)*

10.21 Хараат бус комисс сонгуулийн үйл явцын талаар саналын эрхтэй Бүх гишүүдийн төлөөлөгчдийн асуулт тодруулгад хариу өгөх, мэдээллээр хангах үүрэгтэй.

Сонгуулийн санал авах, дүнг гаргахдаа дараах аргачлалаар явуулна:

10.22 Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчдийн сонгуулийг дараах аргачлалаар явуулна.

10.22.1 Ерөнхийлөгчид нэр дэвшигч нь Холбооны дүрмийн 12.1-д заасны дагуу Их хурлын төлөөлөгчдийн энгийн олонх буюу 50%-иас дээш санал авсан (50%+1 санал)-н санал авсан тохиолдолд сонгогдоно.

10.22.2 Хэрэв нэр дэвшигчид 50%-иас дээш санал аваагүй тохиолдолд хамгийн олон санал авсан 2 нэр дэвшигчдийн дунд дахин санал хурааж шийдвэрлэх бөгөөд ингэхдээ нийт саналын 50-с дээш хувийн санал авсан нэр дэвшигч сонгогдсонд тооцогдоно.

10.23 Дэд ерөнхийлөгчийн сонгуулийг дараах аргачлалаар явуулна.

10.23.1 Дэд ерөнхийлөгчид нэр дэвшигч нь Холбооны дүрмийн 12.6-д заасны дагуу хамгийн олон авсан дөрвөн нэр дэвшигчид багтсан тохиолдолд сонгогдоно.

10.23.2 Хэрвээ дөрөв болон тав дахь хамгийн олон санал авсан нэр дэвшигчдийн саналын тоо тэнцсэн тохиолдолд тэнцүү тооноос илүү санал авсан нэр дэвшигчийн сонгогдсонд тооцож, зөвхөн тэнцүү тоотой санал авсан нэр дэвшигчдийн хооронд дахин санал хураалт явуулан, хамгийн олон саналтай нь сонгогдох зарчмыг баримтална.

- 10.24 Удирдах Зөвлөл болон Хяналтын зөвлөлд нэр дэвшигчдийн сонгуулийг дараах аргачлалаар явуулна.
- 10.24.1 Их хурлын төлөөлөгчдийн ердийн олонхи (50%+1 санал)-н санал авсан тохиолдолд сонгогдоно.
- 10.24.2 Саналын тоо тэнцсэн тохиолдолд дахин санал хураалт явуулан, хамгийн олон саналтай нь сонгогдох зарчмыг баримтална.
- 10.25 Санал өгөөгүй хоосон хуудас, саналын хуудсыг засварласан, илүү тэмдэглэгээ хийсэн, дүрмийн 9 дүгээр зүйлээр тогтоосон сонгуульт албан тушаалтан тус бүрийн тооноос илүү эсхүл дутуу тоогоор нэр дэвшигчид санал өгсөн бол уг саналыг хуудсыг хүчингүйд тооцно.
- 10.26 Их хурлын гишүүн санал өгөх явцдаа зөвхөн нэг удаа Хараат бус комисст хүсэлт гарган комиссын шийдвэрээр өмнөх саналын хуудсаа хүлээлгэн өгч, шинэ саналын хуудас сольж авах эрхтэй. Энэ тохиолдолд хуучин саналын хуудсыг устгаж энэ тухай тэмдэглэл хөтөлж албажуулна.
- 10.27 Хүндэтгэн үзэх шалтгааны улмаас их хурлын гишүүн нь саналаа биечлэн өгөх боломжгүй бол санал хураалт явагдаж буй тэр агшинд өөрийн саналаа цахимаар Харат бус комисст илгээх эрхтэй.

Арван нэг. ХОЛБООНЫ УДИРДАХ ЗӨВЛӨЛ

- 11.1. Их хурлын чөлөөт цагт холбооны эрх барих байгууллага нь Удирдах Зөвлөл байна.
- 11.2. Удирдах зөвлөлийг Холбооны Их хурлаас 4 жилийн хугацаатайгаар сонгон томилно.
- 11.3. Удирдах зөвлөл нь 5-аас дээш 15 (арван тав) хүртэлх тооны сондгой тооны бүрэлдэхүүнтэй байна. Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд Олимпийн Хартид заасан жендерийн хувь (11)-ийг баримтална.
- 11.4. Холбооны Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд Ерөнхийлөгч, дөрвөн Дэд Ерөнхийлөгч, Удирдах зөвлөлийн гишүүд багтана.
- 11.5. Холбооны Ерөнхийлөгч нь Удирдах зөвлөлийн Тэргүүн байна.
- 11.6. Холбооны УЗ-ийн гишүүн нь Холбооны удирдлагын бусад албан тушаалууд болон УЗ-ийн дэргэдэх зөвлөлүүдэд ажиллахгүй.
- 11.7. Удирдах зөвлөл нь улиралд нэгээс доошгүй удаа ердийн олонхийн ирцтэй хуралдаж, доорхи асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ. Үүнд:
- 11.7.1 Холбооны стратеги, хөгжлийн бодлого, хэтийн төлөвийг тодорхойлох
- 11.7.2 Үйл ажиллагаа, санхүүгийн төлөвлөгөөг хэлэлцэн батлах
- 11.7.3 Олимп, дэлхий, тивийн аварга шалгаруулах тэмцээнд оролцох тамирчин, дасгалжуулагчийг батламжлах

- 11.7.4 Дүрмийн 11.7.3-т заасан болон олон улсын зэрэглэлийн бусад тэмцээнд Холбооны гишүүн тамирчныг олон улсад түгээмэл зарчмаар сонгон шалгаруулах, оролцуулах журмыг батлах
 - 11.7.5 Уралдаан, тэмцээн, сургалтын нэгдсэн хуваарийг батлах.
 - 11.7.6 Гишүүд, гишүүн клубүүдийн татварын хэмжээг тогтоох.
 - 11.7.7 Ажлын алба, санхүү, тэмцээн уралдааны тайланг хэлэлцэн үнэлэлт дүгнэлт өгөх
 - 11.7.8 Шагнал урамшуулалд нэр дэвшигчдийг батлах.
 - 11.7.9 Холбооны Хүндэт Ерөнхийлөгчийг батламжлах.
 - 11.7.10 Байгууллагын дотоод журам батлах
 - 11.7.11 Бусад
- 11.8. Удирдах Зөвлөлийн хурлын шийдвэр хуралд оролцогчдын энгийн олонхийн саналаар хүчин төгөлдөр болно. УЗ-ийн хурлын шийдвэр тогтоол хэлбэрээр гарч тогтоолд Ерөнхийлөгч гарын үсэг зурна.
- 11.9. Хурлын тэмдэглэлийг ЕНБД хөтөлж, 7 хоногийн дотор УЗ-н гишүүдэд тэдгээрийн цахим хаягаар хүргүүлнэ.

Арван хоёр. ХОЛБООНЫ ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА

Ерөнхийлөгч

- 12.1. Ерөнхийлөгчийг Их хурлын төлөөлөгчдийн ердийн олонхийн санал хураалтаар сонгох бөгөөд Ерөнхийлөгч нь Их хурлын хугацаагаар зөвхөн нэг удаа сонгогдоно.
- 12.2. Ерөнхийлөгчид нэр дэвших этгээд нь 10.11-д заасан шаардлагыг хангасан байна.
- 12.3. Ерөнхийлөгч нь Холбоог удирдах дээд албан тушаалтан байх бөгөөд дараах бүрэн эрхтэй байна.
 - 12.3.1. Холбооны үйл ажиллагааг ерөнхий удирдлагаар хангах
 - 12.3.2. Холбоог Олон Улсын болон Үндэсний хэмжээнд албан ёсоор төлөөлөх,
 - 12.3.3. Их хурал болон Удирдах зөвлөлийн хурлыг даргалах,
 - 12.3.4. Их хуралд ажлаа тайлагнах;
 - 12.3.5. Санхүүгийн баримтанд Нэгдүгээр гарын үсэг зурж, тайлан тэнцлийн үнэн зөвийг хариуцах;
 - 12.3.6. Усан спортын тамирчин, дасгалжуулагч, аж ахуйн нэгж, байгууллага, хуулийн этгээдтэй байгуулсан гэрээ хэлэлцээрийг батлах,
 - 12.3.7. Холбооны Хүндэт Ерөнхийлөгчөөр өргөмжлөх иргэнийг УЗ-д санал болгон батламжлуулах

- 12.3.8. Их хурлаас сонгогдсон Дэд Ерөнхийлөгч нараас Тэргүүн Дэд ерөнхийлөгчийг сонгож, чөлөөлөх,
- 12.3.9. Тэргүүн дэд ерөнхийлөгч, дэд ерөнхийлөгч нарын чиг үүргийг хуваарилах
- 12.3.10. ЕНБД томилох, чөлөөлөх, хэрэгжүүлэх чиг үүрэг, ажил үүргийн хуваарийг батлах, түүнтэй хөдөлмөрийн харилцаатай холбоотой гэрээ, хэлцэл байгуулах
- 12.3.11. Холбооны үйл ажиллагаанд шаардлагатай зарим бүтцийг байгуулах буюу ажлын албыг томилох, чөлөөлөх (Ажлын алба нь сургалт, судалгаа явуулах, мэдээлэл хүргэх, зөвлөгөө өгөх, уралдаан тэмцээний мэргэжлийн туслалцаа үзүүлэх ажлыг зохион байгуулна.)
- 12.3.12. Аймаг, Нийслэлийн салбар, зөвлөлийн тэргүүнээр сонгогдсон этгээдийг батламжлах
- 12.4. Ерөнхийлөгч албан үүргээ түр, эсвэл бүр мөсөн гүйцэтгэх боломжгүй болсон, өөрийн хүсэлтээр татгалзсан тохиолдолд дараагийн ээлжит Их хурал болтол түүний үүргийг Тэргүүн дэд ерөнхийлөгч хэрэгжүүлнэ.
- 12.5. Холбооны Ерөнхийлөгчөөр ажиллах хугацаандаа Холбооны үйл ажиллагаанд үнэтэй хувь нэмэр оруулсан этгээдийг “Хүндэт Ерөнхийлөгч”-өөр өргөмжилнө. “Хүндэт Ерөнхийлөгч” нь Холбооны УЗ-ийн хуралд оролцож зөвлөх эрхтэй байна.

Дэд ерөнхийлөгч

- 12.6. Дэд Ерөнхийлөгчийг Холбооны Их Хурлын төлөөлөгчдийн санал хураалтаар хамгийн олон санал авсан дөрвөн нэр дэвшигч нь Их хурлын хугацаагаар сонгогдоно.
- 12.7. Дэд ерөнхийлөгчид нэр дэвших этгээд нь 10.11-д заасан шаардлагыг хангасан байна.
- 12.8. Холбоо нь дөрвөн (4) Дэд ерөнхийлөгчтэй байна.
- 12.9. Дэд ерөнхийлөгч нь Холбооны хэтийн төлөвлөлт, санхүү эдийн засаг, хөгжил, тогтвортой байдлын чиглэлээрх асуудал хариуцна.
- 12.10. Дэд ерөнхийлөгч нь Удирдах зөвлөлийн дэргэдэх тамирчдын, дасгалжуулагчийн, шүүгчийн, ёс зүйн зөвлөл болон эрдэм шинжилгээ судалгаа, гадаад харилцаа, мэдээлэл сурталчилгааны багийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.
- 12.11. Дэд Ерөнхийлөгчийн эрх, үүрэг:
- 12.10.1. Холбооны үйл ажиллагааг мэргэжлийн аргазүйн удирдлагаар хангах
 - 12.10.2. Холбооны ажлын хэсгүүдийн үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах
 - 12.10.3. Уралдаан тэмцээн зохион байгуулах, тэмцээнд оролцох төлөвлөгөө боловсруулах, спортын байгуулагуудын үйл ажиллагаатай холбооны үйл ажиллагааг уялдуулах

- 12.10.4. Ерөнхийлөгчийн болон Ерөнхий нарийн бичгийн хэн нэг нь эзгүйд түүний эрх үүргийг хавсран гүйцэтгэнэ.
- 12.10.5. Хариуцсан чиглэлтэй холбоотой шийдвэр гаргуулах шаардлагатай тохиолдолд Ерөнхийлөгчтэй зөвшилцсөний үндсэнд УЗ-д танилцуулна.
- 12.12. Ерөнхийлөгчийн томилсон нэг Дэд Ерөнхийлөгч нь холбооны Тэргүүн Дэд Ерөнхийлөгч байх ба энэхүү дүрэмд заасан эрх үүргээс гадна дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:
- 12.11.1. Холбооны Ерөнхийлөгчийн эзгүйд Холбоог төлөөлөх
- 12.11.2. Холбооны дүрмийн хүрээнд Ерөнхийлөгчийн хуваарилсан чиг үүргийг хэрэгжүүлэх

Ерөнхий нарийн бичгийн дарга:

- 12.12. Ерөнхий нарийн бичгийн дарга нь дээд боловсролтой, усан спортыг хөгжүүлэх чин эрмэлзэлтэй, мэргэшсэн, багаар ажиллах, удирдан зохион байгуулах чадвар, туршлагатай Монгол Улсын иргэн байна.
- 12.13. Ерөнхий нарийн бичгийн даргыг Ерөнхийлөгчийн санал болгосноор Удирдах зөвлөлийн хурлаар сонгож, чөлөөлөх бөгөөд орон тооны байна.
- 12.14. Ерөнхий нарийн бичгийн дарга нь Ерөнхийлөгчтэй гэрээ байгуулах ба гэрээгээр талуудын эрх, үүрэг, ажлын чиг үүрэг, захиран зарцуулах мөнгөн хөрөнгийн хэмжээ болон бусад асуудлыг зохицуулна.
- 12.15. Ерөнхий нарийн бичгийн даргын эрх, үүрэг:
- 12.15.1. Их хурал, Удирдах Зөвлөлөөс гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэн Холбооны өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, Удирдах зөвлөлөөс олгосон эрхийн хүрээнд шийдвэр гаргаж, Удирдах зөвлөлд ажлаа тайлагнах, санал оруулах,
- 12.15.2. Их хурал, УЗ-ийн хурал бусад зөвлөлүүдийн хурлыг зохион байгуулах, хурлын тэмдэглэл хөтлөх, хурлаас гарсан шийдвэрийг хэрэгжилтийг хангах, гишүүдийг мэдээллээр хангах,
- 12.15.3. Дасгалжуулагч, тамирчинтай гэрээ, хэлцэл хийх,
- 12.15.4. Холбооны үйл ажиллагааны харилцааг зохицуулах, уралдаан тэмцээн зохион байгуулах дүрэм журам, Жилийн ажлын болон спорт, тэмцээний календарчилсан төлөвлөгөө, төсөв, орон тоо, бодлогын чанартай бичиг баримтыг боловсруулан бэлтгэж, Удирдах зөвлөлийн хуралд оруулан хэлэлцүүлж, шийдвэрлүүлэх,
- 12.15.5. Удирдах зөвлөлийн дэргэдэх зөвлөл, багийг өдөр тутмын удирдлагаар хангаж, хамтран ажиллах, тэдний асуудлыг холбогдох хүмүүст танилцуулж шийдвэрлүүлэх,

- 12.15.6. Холбооны үйл ажиллагаа, усан спортын уралдаан тэмцээнийг мэдээллийн хэрэгслээр олон нийтэд ил тод сурталчлах,
- 12.15.7. Гадаад харилцааг өргөжүүлэх үйл ажиллагаа бодитой явуулах,
- 12.15.8. Холбооны тэмдэг, туг далбаа, бичиг баримт, бусад зүйлсийг үйл ажиллагаанд ашиглах, хадгалах, хамгаалах, архивлах, өмч хөрөнгийг бүртгэн хяналт тавих,
- 12.15.9. Жилийн эцсийн ажлын болон санхүүгийн тайлан тэнцлийг гаргуулж, Удирдах зөвлөлийн хуралд оруулах
- 12.15.10. Гадаад, дотоодод зохион байгуулагдах тэмцээнийг хариуцаж ажиллах

Арван гурав. ХОЛБООНЫ УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ ЗӨВЛӨЛ, БАГ

13. Холбооны Удирдах Зөвлөлийн дэргэд дараах Зөвлөл, баг ажиллана.

13.1. Дасгалжуулагчийн зөвлөл:

- 13.1.1. Зөвлөлийн бүрэлдэхүүнд олон улс, тив, дэлхий, Олимпын наадамд тамирчид нь шалгаран оролцдог, үндэсний шигшээ багийн тамирчдыг дасгалжуулдаг, аль нэг клубт тамирчдынхаа өдөр тутмын бэлтгэл, сургалтыг тогтмол хариуцдаг мэргэжлийн дасгалжуулагчид орно.
- 13.1.2. Удирдах зөвлөлөөс баталсан журмыг мөрдлөг болгон ажиллана.
- 13.1.3. Дасгалжуулагчийн зөвлөлд 7 (долоо) хүн байна. Өөрийн бүрэлдэхүүнээс зөвлөлийн даргыг нууц санал хураалтаар ердийн олонхийн зарчмаар сонгож, Холбооны Удирдах зөвлөлд санал оруулж батлуулна. Дасгалжуулагчийн зөвлөлийн дарга нь үндэсний шигшээ багийн ахлах дасгалжуулагчид нэр дэвшинэ.

13.2. Шүүгчдийн зөвлөл:

- 13.2.1. Холбооноос баталсан төлөвлөгөөний дагуу дотоодод зохиогдох тэмцээнд ажиллах шүүгчдийн бүрэлдэхүүнийг томилох, бэлтгэх, заавар зөвлөмж өгөх, ОУУСХ-ны дүрмийг хэрэгжүүлэх, түүнд орсон нэмэлт, өөрчлөлтүүдийг дасгалжуулагч, тамирчдад тухай бүр танилцуулж мөрдүүлэх үүрэгтэй.
- 13.2.2. Холбооны Удирдах зөвлөлөөс баталсан журмыг мөрдлөг болгон ажиллана.
- 13.2.3. Шүүгчдийн зөвлөл нь 5 (тав) хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд бүрэлдэхүүнээсээ даргаа нууцаар санал хураан сонгож, Удирдах зөвлөлд оруулж, батлуулна.

13.3. Тамирчдын зөвлөл:

- 13.3.1. Усан спортын тамирчдын эрх ашгийг хамгаалах, тэдний эрүүл мэнд, нийгмийн асуудлыг анхаарч тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлж, туслах үүрэгтэй.
- 13.3.2. Тамирчдын хурлаар 5 (тав) хүнийг зөвлөлийн тэргүүлэгчээр сонгож, тэргүүлэгчдээсээ даргаа нууцаар санал хураан сонгон, Удирдах зөвлөлөөр батлуулна. Удирдах зөвлөлөөс баталсан журмыг мөрдлөг болгон ажиллана.

13.4. Ёс зүйн зөвлөл:

13.4.1. Холбооны гишүүдийн ёс суртахууны харилцааг зохицуулж, тэдний дагаж мөрдөх хэм хэмжээг тогтоон ёс зүйн зөрчлөөс сэргийлэх, Холбооны гишүүдийн нэр төрийг хамгаалах үүрэгтэй. Холбоонь ёс зүйн дүрэмтэй байх бөгөөд дүрмийг Ёс зүйн зөвлөлөөс санал болгосоноор Удирдах зөвлөл батална.

13.4.2. Ёс зүйн зөвлөлийг Удирдах зөвлөлөөс байгуулна.

13.4.3. Ёс зүйн зөвлөл нь дотоод журмаа Удирдах зөвлөлөөр батлуулан мөрдлөг болгож ажиллана. Зөвлөлийн бүрэлдэхүүнд 5 (тав) хүний нэрийг дэвшүүлж, бүрэлдэхүүнээсээ даргаа нууцаар санал хураан сонгон, Удирдах зөвлөлөөр батлуулна.

13.5. Эрдэм шинжилгээ, сургалт, судалгааны баг:

13.5.1. Усан спортын статистик судалгаа гаргах, сургалт дасгалжуулалтын шинжлэх ухааны үндэслэлийг боловсруулж, дасгалжуулагч, тамирчдын ажиллах арга барилд дүн шинжилгээ хийж, зааварчилга өгөх, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын чиглэл, үр өгөөжийг дээшлүүлж, монгол хүний онцлогт тохирсон дасгалжуулалтын арга, технологийг бэлтгэн, сургалт явуулах, судлаж боловсруулахад ажлаа чиглүүлнэ.

13.5.2. Эрдэм шинжилгээ, сургалт, судалгааны баг нь 5 (тав) хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд ахлагч нь эрдэм шинжилгээ, судалгааны ажлын туршлагатай, эрдмийн ажил туурвисан, магистр болон түүнээс дээш цолтой байна. Өөрийн бүрэлдэхүүнээсээ багийн ахлагчаа нууцаар санал хураан сонгож, дотоод журам, ажлын чиглэлийг Удирдах зөвлөлөөр батлуулна.

13.6. Гадаад харилцаа, мэдээлэл, сурталчилгааны баг:

13.6.1. Холбооны олон талт болон хоёр талын хамтын ажиллагааг хөгжүүлэхэд идэвхтэй үйл ажиллагаа явуулна.

13.6.2. Холбооны үйл ажиллагаа, усан спортыг Холбооны вэб хуудас, бусад хэвлэл, мэдээллийн хэрэгслүүдээр байнга сурталчилна.

13.6.3. Удирдах зөвлөл болон дасгалжуулагч, тамирчдыг усан спортын холбогдолтой шинэ мэдээллээр хангана.

13.6.4. Гадаад харилцаа, мэдээлэл, сурталчилгааны багийн ахлагч нь мэргэжлийн ажлын дадлага, туршлагатай байх бөгөөд Удирдах зөвлөлөөс бүрэлдэхүүн, ахлагчийг томилон ажиллуулна.

Арван дөрөв. ХОЛБООНЫ ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛ

14.1. Хяналтын Зөвлөлийг Холбооны Их Хурлын төлөөлөгчдийн ердийн олонхийн нууц санал хураалтаар сонгох бөгөөд зөвлөл нь Их Хурлын хугацаагаар сонгогдоно.

- 14.2. Хяналтын Зөвлөл 3 хүний бүрэлдэхүүнтэй ажиллан Зөвлөлийн хурлаас даргыг сонгоно.
- 14.3. Хяналтын Зөвлөл нь Холбооны гишүүдийн үйл ажиллагаа, төлөвлөгөөний хэрэгжилт, хөрөнгийн зарцуулалтад хяналт тавина.
- 14.4. Хяналтын Зөвлөл нь Удирдах Зөвлөлийн хуралд зөвлөх эрхтэй оролцоно.
- 14.5. Холбооны хяналтын үйл ажиллагааг Хяналтын зөвлөл хэрэгжүүлнэ.
- 14.6. Хяналтын зөвлөл нь Холбооны хөрөнгө, санхүү, аж ахуйн үйл ажиллагаа, удирдах бүрэлдэхүүн, дасгалжуулагч, тамирчин, шүүгчдийн ёс зүй, Удирдах зөвлөлийн хурлын тогтоол, Ерөнхийлөгчийн тушаал, Холбооны дүрэм, бусад холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын биелэлтэнд хяналт тавьж, шаардлагатай бол шалгалт явуулна.
- 14.7. Санал, өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэнэ.
- 14.8. Холбооны үйл ажиллагаанд хийсэн шалгалт, хүсэлт, өргөдөл гомдлыг зөвлөлөөрөө хэлэлцэн шийдвэрлэх, Холбооны Ерөнхийлөгчид танилцуулж, Удирдах зөвлөлийн хуралд оруулж, шаардлагатай гэж үзвэл хууль хяналтын байгууллагад шилжүүлж шийдвэрлүүлнэ.

Арван тав. ЛИЦЕНЗ

- 15.1 Лицензи гэдэг нь зөвхөн Холбооноос тусгай батлагдсан журмын хүрээнд олгогдох эрх, батламж, гэрээг хэлнэ.
- 15.2 Лицензийг холбооны дүрмийн болон бусад зөрчилгүй дараах этгээд эзэмшинэ. Үүнд:
- 15.2.1 Дасгалжуулагч
- 15.2.2 Клубын тамирчин
- 15.2.3 Шүүгч
- 15.3 Бие даасан клубүүд лицензи эзэмшигч байж болох ба энэ төрлийн харилцааг Удирдах зөвлөлөөс баталсан гэрээгээр зохицуулна.
- 15.4 Лиценз нь үүрэг зориулалтаас хамаарсан тус тусын үнэтэй байна. Үнийг Удирдах зөвлөлөөс тогтооно.

Арван зургаа. ДОПИНГИЙН ХЯНАЛТ

- 16.1 ОУОХ-ны дүрэм (харт)-ийн 2.8 заалт, Дэлхийн, Допингийн Эсрэг Агентлагийн дүрэм (WADA), Олон улсын холбооны дүрэмд допингийн эсрэг тусгагдсан заалтуудыг хэрэгжүүлэх

16.1.1 Допингийн сургалт явуулах

16.1.2 Допингийн шинжилгээ авах

16.1.3 Допинг хэрэглэсэн тохиолдолд авах арга хэмжээ авах

Арван долоо. ХОЛБООНЫ ЭД ХӨРӨНГӨ, САНХҮҮЖИЛТ

17.1 Холбоо өөрийн мөнгөн сан, эд хөрөнгөтэй байна. Үүний эх үүсвэрийг дараахи хэлбэрээр бүрдүүлнэ:

17.1.1 Гишүүдийн татвар

17.1.2 Дотоод, гадаадын байгууллага, хувь хүний хандив

17.1.3 Дүрмийн зорилгоо хэрэгжүүлэхтэй холбогдсон аж ахуйн үйл ажиллагааны орлого

17.1.4 Төсөл хэрэгжүүлэх зорилгоор улсын төсвөөс болон олон улсын байгууллагаас олгосон хөрөнгө

17.1.5 Төрийн байгууллагын санхүүгийн дэмжлэг

17.2 Холбооны гишүүн, байгууллага, клуб, хувь хүн жилд нэг удаа, жил бүрийн 3 дугаар сарын 31-ний өдрийн дотор, тогтоосон хэмжээгээр татвар төлнө. Холбооны хүндэт гишүүн татвараас чөлөөлөгдөнө.

17.3 Гишүүний татварын хэмжээг Удирдах Зөвлөлөөс тогтоосон хязгаарын дотор жил бүр тогтооно.

17.4 Гишүүн элсэхэд тэмдэгтийн хураамж, үнэмлэхний үнийг гишүүд төлсөн байна. Гишүүдийн татвар, хандивын орлогыг Холбооны дансанд шилжүүлсэн байна.

17.5 Холбоо нь банкинд төгрөгийн болон валютын, данстай байна.

17.6 Данстай харьцах эрхийг Холбоонд Ерөнхий нарийн бичгийн дарга, клубд өдөр тутмын үйл ажиллагааг удирдаж байгаа гүйцэтгэх ажилтан эдлэнэ.

17.7 Холбоо нь төвлөрсөн сантай байж болох бөгөөд түүнийг зарцуулах журмыг Удирдах Зөвлөл батлана.

17.8 Холбооны хөрөнгө, санхүүгийн тайлан тэнцэл нь ил тод байна.

17.9 Энэ дүрмийн 7.1-д заасан эх үүсвэрийг Холбооны дансанд төвлөрүүлнэ.

Арван найм. МУССХ-НЫ ЯЛГАРАЛ

18.1 Холбоо нь бэлгэдэл (лого), туг, энгэрийн тэмдэгтэй байна.

- 18.2 Холбооны бэлгэдэл, тугийн загвар, хэрэглэх журмыг Холбооны Удирдах зөвлөлийн хурлаар батална.
- 18.3 Холбооны бэлгэдэлийг Холбооны салбар холбоод нь туг, зурагт хуудас, ном, албан бичиг болон веб хуудас, зүүлт, хаяг, медаль, дурсгалын тэмдэг, дарцаг, багийн бүрэлдэхүүний болон шүүгчдийн хувцас, хэрэглэл, ном сэтгүүл зэрэгт хэрэглэх бөгөөд МУССХ-ны гишүүн холбоо, клуб болон албан ёсны гэрээт түнш байгууллага мөн нэгэн адил хэрэглэж болно.
- 18.4 Холбооны шигшээ багийн бүрэлдэхүүн, шүүгчид нь дотоодод болох тэмцээнд холбооны лого, Холбооны шүүгч гэсэн бичиг бүхий дүрэмт болон багийн хувцастай байна. Дүрэмт хувцасны загвар, хэрэглэх журмыг Удирдах зөвлөл тогтооно.
- 18.5 Холбоо нь өөрийн Дээд шагналтай байна. Шагналын нэр, хэлбэр, олгох болзол журмыг Удирдах зөвлөлөөс тогтооно.
- 18.6 Холбооны цахим хуудас, ЕНБД-ны холбоог төлөөлж бусад байгууллагатай харилцах цахим хаяг, домэйн зэрэг Холбооны өмч байна.

Арван ес. ХОЛБООГ ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАХ, ТАТАН БУУЛГАХ

- 19.1 Холбооны үйл ажиллагааг зогсоох, эд хөрөнгийг хэрхэх асуудлыг "Төрийн бус байгууллагын тухай" Монгол Улсын хуулийн 1-р бүлгийн 7-р зүйлийн 2, 3 дахь заалтын дагуу Холбооны Их Хурал шийдвэрлэнэ.
- 19.2 Энэхүү дүрэм 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

МОНГОЛЫН УСАН СПОРТ СОНИРХОГЧДЫН ХОЛБООНЫ ЭЭЛЖИТ ИХ ХУРАЛ

2022 оны 06 дугаар сарын 10-ны өдөр

BYLAWS OF THE MONGOLIAN AMATEUR SWIMMING FEDERATION NGO

ONE. GENERAL PROVISIONS

- 1.1. Name of the Organization: “Mongolian Amateur Swimming Federation”, abbreviated as MASF (hereinafter referred to as the “Federation”), in Mongolian: “Монголын Усан Спорт Сонирхогчдын Холбоо”, abbreviated as МУССХ.
- 1.2. Date of Establishment: 01 January 1991.
- 1.3. Address: 1st floor, “Capital House” Building, 48/1 Chinggis Avenue, 1st Khoroo, Khan-Uul District, Ulaanbaatar, Mongolia.
- 1.4. The Federation is a non-profit, non-governmental organization established on the basis of voluntary participation of individuals who practice, support, and are interested in aquatic sports. It operates with membership and aims to develop aquatic sports in Mongolia for the benefit of society.
- 1.5. The Federation shall conduct its activities in compliance with the Constitution of Mongolia, the Civil Code, the Law on Non-Governmental Organizations, and other relevant legislation.

TWO. MISSION AND OBJECTIVES OF MASF

- 2.1. The mission of the Federation is to develop aquatic sports in Mongolia, increase public participation, enhance opportunities for Mongolian athletes to compete successfully at Asian, World, and Olympic levels, train high-performance athletes, and promote Mongolia internationally through aquatic sports.
- 2.2. To coordinate, support, and guide the activities of individuals who practice, support, and are interested in aquatic sports.
- 2.3. To encourage initiatives and research activities, study international best practices, and develop and implement training and coaching methodologies that are suitable for the characteristics of Mongolian athletes.
- 2.4. To create favorable conditions and an enabling environment for the training and development of coaches and athletes.
